

Анхдугаар ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 44 (2308)

1974 оны 6 дугаар сарын 8

БЯМБА

АРДЫН ХУВЬСГАЛЫН 53 ЖИЛИЙН ОЙГ АЖЛЫН ИХ АМЖИЛТААР УГТЪЯ

Ардын Хувьсгалын яруу алдарт 53 жилийн ойг тэмдэглэхэд сар гаруй хугацаа үлдлээ.

Ардын Хувьсгалын 53 жилийн ойдоо манай аймгийн бүтээлч хөдөлмөрдийн барих бэлэг бол энэ оны эхний хагас жилийн аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх ба давуулж биелүүлэх явдал мөн. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1974 онд бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэх, малын зүй бусын хорогдлыг багасгах, малын төлийг бүрэн хүлээн авч бойжуулах арга хэмжээний тухай чухал шийдвэрүүдийг гаргасан билээ. Эдгээр шийдвэрүүд болон аймгийн намын хорооны VI бүгд хурлаас, энэ онд мал өсгөх хөдөлмөрийг төлөвлөгөөг таван төрөл дээр нь биелүүлж дүнгээр нь 1975 оны хэмжээнд хүргэж өсгөх, малын зүй бусын хорогдлыг аймгийн онцгой комиссоос өгсөн даалгаврын хэмжээнд хүртэл багасгах, 100 хээлтэгчээс МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын заалтаас нэг төл илүү бойжуулах зорилт дэвшүүлснийг манай малчид, МАА-н мэргэжилтнүүд баяртай хүлээн авч тодорхой амжилт гаргаж байна.

Аж ахуй, соёлын салбар, нэгж бүрт социалист уралдааныг өрнүүлэн хүмүүсийн идэвх санаачилгыг өрнүүлэн ажилласны үр дүнд эхний 5 сарын байдлаар төл бойжуулах төлөвлөгөөг 101,2 хувиар биелүүлж 5,9 мянган төл илүү бойжуулан зүй бусын хорогдлыг өнгөрсөн оны энэ үеийнхээс 46,2 хувиар багасгав. Тариаланчид 112,2 мянган га газарт үрлэлт хийгээд байгаагийн дотор үр тариа тариалалтыг 101,0 хувиар биелүүллээ.

Үйлдвэр аж ахуйн газрууд бүтэн 5 сарын үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлж 5835,9 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд байна. Гэвч зарим үйлдвэрийн газрын нэр төрлийн төлөвлөгөө тасалдаж, бэлтгэлийн төлөвлөгөөт ажил ялангуяа ноос, цоолуур, хөөвөр, хялгас бэлтгэх ажил удаашралтай явагдаж байгааг анхаарч энэ ажлын эрч далайцыг нэмэгдүүлж хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулбал зохино.

Их ойн өмнө эхний хагас жилийн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган уралдаанд ансан үүргээ давуу, биелүүлэх нь манай нэгдэл, САА, ТАА, худалдаа бэлтгэл, үйлдвэр, барилга, зам, тээвэр, холбоо, нийгэм, соёлын байгууллагуудын гол зорилт болж байна. Ардын хувьсгалын 53 жилийн ойг угтаж эхний хагас жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэхийн тулд уралдааныг улам эрчимжүүлж явцыг өдөр, долоо, арав хоногоор дүгнэн байр эзлүүлэн зэрэгцүүлж, олон түмний өмнө ид тавьж ололт амжилтыг сурталчлан дэлгэрүүлж урамшуулах, дутагдлын шалтгааныг илрүүлэн засах арга хэмжээг байнга авч эрч хүчийг улам нэмэгдүүлэх ажлыг орон нутгийн нам, улс, олон нийтийн байгууллага сайн зохион байгуулах хэрэгтэй. Мөн отор нүүдлээр мал ногоолуулж таргалуулах, өргөн айлсалтын бэлтгэлийг хангах, бүх төрлийн малд үзлэг ангилалт хийж угаалгыг дуусгах, үнээ хээлтүүлгийг сайн зохион явуулах, уршилалт, хашаа барих, засварлах, малын сүү шим, ноос үсийг бүрэн дүүрэн авч ашиглах асуудалд ХАА-н хамт олон бүх хүч бололцоо дайчлан ажиллах ёстой. Хот суурин газар, бригад, фермийн төв гудамж талбайг тохижуулан, хүн амын ахуй соёлын үйлчилгээний чанарыг улам дээшлүүлэх нь ой угтсан ажлын нэг хэсэг мөн.

Манай төв, хөдөөгийн аж ахуй соёлын бүх газар байгууллагууд өндөр бүтээлийн уралдааныг ажлын салбар нэгж, хүн бүрийн хооронд өрнүүлэн төлөвлөгөөт зорилтыг биелүүлдэн амжилтаар Ардын хувьсгалын 53 жилийн ойг угтагчаа!

Борнуур сумын намын хорооны
нарийн бичгийн дарга Д. ЧҮЛТЭМ,
АДХ-ын гүйцэтгэх захиргааны
дарга Т. ДЭЧИННЭЛ нар

Танай сумын нам, улс, олон нийтийн байгууллага, хамт олон социалист уралдааныг өрнүүлж бодин халгас, ямааны нос, ноолуур бэлтгэх төлөвлөгөөг хугацаанд нь 101,9—121,5 хувиар биелүүлдэг үлдээд. Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа баар хүргэж, наамид аж ахуй, соёлын төлөвлөгөөг ажлуудаа хугацаанд нь биелүүлдэгэдт Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа бат итгэж байна.

Аймгийн Намын хорооны нэгдүгээр
нарийн бичгийн дарга Ц. АДЪЯА
Аймгийн АДХ-ын гүйцэтгэх
захиргааны дарга Ч. ДАШДЭМБЭРЭЛ

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 6 дугаар сарын 2-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 81,4 хувь буюу 516,1 мянга нь төлөж гарсан төлийн 98,3 хувь буюу 511,8 мянга нь бойжиж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 22,9 хувь буюу 95,4 мянгаар илүү байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүлбэл:

Сумдын нэрс	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баянцагаан	99,9	1
Угтаал	99,8	2
Баян	99,8	3
Баянцогт	99,5	4
Сэргэлэн	99,5	5
Баянжаргалан	99,4	6
Эрдэнэсант	99,3	7
Лүн	99,2	8
Баянзүрх	99,1	9
Дэлгэрхаан	99,0	10
Баян-өнжүүл	99,0	11
Алтанбулаг	98,9	12
Өндөрширээт	98,9	13
Мөнгөнморьт	98,7	14
Баянчандмань	98,7	15
Батсүмбэр	97,7	16
Борнуур	97,7	17
Бүрэн	96,8	18
Эрдэнэ	95,6	19
Жаргалант	95,4	20
Баяндэлгэр	95,0	21
Заамар	93,4	22

Статистикийн товчоо

150000 төгрөгийн бүтээгдэхүүнээр

Аймгийн Ойн аж ахуйн хамт олон 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд тооцоотой үүрэг авч ажиллаад эхний 5 сарын үйлдвэрийн төлөвлөгөөг 11,7 хувиар давуулан, төлөвлөгөөнөөс 150 гаруй мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэлээ. Баянчандмань дахь Цэнд даргатай модны үйлдвэр сар бүрийн төлөвлөгөөг 107,7—131,3 хувиар тогтмол давуулан биелүүлж байна. Аймгийн төвийн гэр ахуйн мод үйлдвэрлэх тасгийн ажилчин аймгийн 3 удаагийн аварга мужаан Мижид, мөн мужаан Н.Цагаан, Р. Жамьяншарав, Ш. Дамдиндорж, Н.Ядамсүрэн, Б.Цэнддорж, С. Хайчин, Н. Батнасан, С. Агваанлуvsан нар хагас жилийн төлөвлөгөөг 35 хоногийн өмнө 7,3—43,3 хувиар давуулан биелүүлж, уралдаанд хошууцлаж явна.

Ц. МӨРНЭРЭН

БҮСИЙН ҮЗЛЭГТ ШАЛГАРЛАА

Саяхан Зуунмод хотод уран сайханчдын урлагийн II шатны үзлэг амжилттай явагдаж, энэ үзлэгт төв, хөдөөгөөс шалгарсан 90 гаруй уран сайханчид авьяас билгээ сорилоо.

Үзлэгээс хөгжмөөр Баянжаргалан сумын клубын эрхлэгч Дашням, Жанчив-лингийн рашаан сувилалын цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багш Баасанжаргал, Баянцогтын САА-н 8 жилийн дунд сургуулийн багш Сүрэнхорлоо, дуугаар НААҮГ-ын ажилчин Цэцгээ, Борнуурын САА-н малчин Цэдэндорж, Хүнсний комбинатын ажилчин Нямсүрэн, бүжгээр Эрдэнэсант сумын ТАА-н ажилчин Чандалдулам, төвийн 8 жилийн дунд сургуулийн сурагч О. Хишигбаяр, Лүн сумын клубын эрхлэгч Буаманжав, уран уншлага Батсүмбэрийн САА-н 8 жилийн дунд сургуулийн сурагч Уранчимэг нарын 19 хүн шалгарч Архангай аймагт болох бүсийн үзлэгт оролцох болов.

Манай сурвалжлагч



Аймгийн нэгдэлтийн эздийн «Мөнх дурсагдах алдар» сэдэвт анхдугаар чуулга уулзалтад оролцож, илгээлтийн эздэд ажлынхаа арвин баялаг туршлагаас ярьсан БНМАУ-ын хөдөлмөрийн баатрууд, ЗУРАГ ДЭЭР: (Өвөр өгнөөнд баруун гараас) Лүн сумын тракторч, комбайнч, хөдөлмөрийн баатар Ч.Шараадорж, Жаргалантын САА-н дарга, хөдөлмөрийн баатар Д.Арваа, Жаргалантын тракторч, комбайнч С.Цагааншүхэрт, Ч.Дугарсүмөн САА-н тракторч, комбайнч М.Чойжамц, Угтаалын САА-н рэн, (Ар эгнээнд зүүн гараас) М.Чойжамц, Угтаалын САА-н тракторч комбайнч, хөдөлмөрийн баатар Г.Алтанхүү, Баян-өнжүүл сумын хоньчин, хөдөлмөрийн баатар Б. Ажваа

ШЕФИЙН ТУСЛАЛЦАА

Аймгийн Барилга угсралтын конторын хамт олон шеф Дэлгэрхаан суманд нэг ээлжинд 20 бод, 59 бог мал эмчилж тэжээж чадах эмчилгээтэжээлийн цэгийн иж бүрэн барилгыг өөрсдийн хүчээр барьж дуусгасан саяхан хүдээлгэн өгч, төлөдлийн дунд зарласан социалист уралдаанаа дүгнэв. Уралдаанд Давст бригадын Б. Доржийн суурь 504 хонь, ямаанаас 515

хурга ишиг бойжуулж 1 дүгээр байр эзэлж алтан хайрцаг нээж баарын бичиг, үнэ бүхий зүйлээр, Осорхүүгийн суурь 505 хонь ямаанаас 507 төд, Тарган бригадын Д. Довчин 631 хонь, ямаанаас 635 хурга ишиг бойжуулж 2 дугаар байр эзэлж барилга конторын зардлаар Улаанбаатар хотод жуулчлах эрхийн бичгээр шагнагдав.

Ш. ЧҮЛТЭМСҮРЭН

НАМЫН БАЙГУУЛЛАГА, СОЦИАЛИСТ УРАЛДААН

Д. ЧУЛТЭМ (Борнуурын САА-н Намын хорооны

Борнуур сумын САА-н намын хороо, 1974 оны социалист уралдаанд байгууллага бригад нэгжээр үүрэг авахуулах ажлыг сумын аж ахуй, соёлын төлөвлөгөөг гардуулах тарын ажилтай хослон доорхи үе шатуудаар явуулсан юм.

Үүнд: Төлөвлөгөөг гардуулж өгөх, ач холбогдлыг сурталчлах, 1973 онд зарласан уралдааныг дүгнэх, 1974 оны уралдааны явцыг хэрхэн эрчимжүүлэх зэрэгт нарийн чиглэл гарган ажиллав.

1974 оны малөвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах, төл бойжуулах, малын ноос үс ашиглах, худал гаргах, хашаа барих, өвс тэжээл бэлтгэх, төмс, хүнсний ногоо тариалах, хурааж авах, техник засваруудыг цаг алдалгүй хийх зэрэг цаг үеийн төлөвлөгөөт ажлуудыг хийлгэхэд богино хэлбэрийн сэдэвт, болзолт уралдаан зарлан дүгнэх аргачлал гарган түүнээ мөрдөж байна.

Уралдааныг тэргүүний туршлага нэвтрүүлэх ажилтай хослон, хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэх ажлыг шинэ шатанд гаргахын тулд улсын тэргүүний сум болсон Ховд аймгийн «Ман-хан», Говь-алтай аймгийн «Халиун», «Бэгэр», Завхан аймгийн «Сант-маргац», «Цэцэн-уул» сумдын туршлагыг хэрэглэж байна.

Манай сумын хөдөлмөрчид сүүлийн 4 жил дараалан социалист уралдааны шагналт байранд орж байсны дотор 1973 онд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв

Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны хүндэт диплом шагналаар шагнагдсан нь манай сумын хөдөлмөрийн хамт олны улс төр, хөдөлмөрийн идэвхийг улам өрнүүлэв.

Социалист уралдаанд түрүүлэгсдэд олгох шагналыг, шилжин явах туг, диплом, үнэмлэх, гэрчилгээ буй болгосны дээр ажлаараа хонорч уралдааны эцсийн байранд үлдэгсдэд шаарлагын хуудас, санамжийг олны өмнө нэмэлт үүрэг амлалт авахуулан өгч байгаа нь социалист уралдаанд авсан үүргээ биелүүлэхэд ач нөлөөтэй зүйл болсон юм.

Намын гишүүн Цэнд ахлагчтай саалийн 5 дугаар бригадын хамт олон аймгийн хэмжээний саалийн бригадуудыг уриалж СХТБ болох амлалт үүрэг авсныг сумын намын хороо дэмжсэн юм.

Намын гишүүн инженер Сономжамц, агрономич Гончиг, малын их эмч Цэрэндагва нар хувийн бүтээлч 2 жилийн төлөвлөгөө зохиож 14 төрлийн үүрэг авч ажилдаа орсны гадна ижил мэргэжлийн бүтээлч бригад болох 2 жилийн хугацаатай үүрэг авах хамт олны хөдөлгөөн өрнөж байна.

Тус САА-н ХАА-н засварын газар, ногооны бригадуудын мэргэжилтнүүд 5 га газарт ойн зурвас байгуулах ажилд ороод хуучин шуудууг ашиглаж тариалалтанд хэрэглэж байгаа зэрэг сайхан эхлэлтүүд гарч байна.

Аймгийн Намын хорооны бүгд хурлын гишүүн С. Хүрлээ, улсын аваргын болзлыг хангах амлалт

нарийн бичгийн дарга)

үүрэг авч 873 хонь төлдүүлж 906 хурга бойжуулж амалсан үүргээ амжилттай биелүүлж байна. Дашдорж даргатай ХБ-ийн ангийн хамт олон СХТ анги болох амлалт үүрэг аваад улирал жилийн бараа, ном, түүхий эдийн төлөвлөгөөнүүдийг тогтмол давуулан биелүүлж байгууллагаа давслагааны болон тордоогоны байр, ажилчдын гуанз, үйлчилгээний мухлаг зэрэг тохижилтын ажлыг хийж СХБ-ын гишүүдийн хүчээр 3-5 гад төмс хүнсний ногоо тариалж авсан ургацаараа аймгийн зарим сумдын гуанзны хэрэгцээг хангаж байна.

Дашням эрхлэгчтэй хүн эмнэлгийн хамт олон, ясли, цэцэрлэг мөн нэгэн адил амлалт үүргээ хугацаанд нь биелүүлэх хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж байгаа юм.

Кино механикч Доолно 5 жилийн төлөвлөгөөт үүргээ 1974 оны эхний хагаст биелүүлэх амлалт аваад ажиллаж байна.

Манай сумын хөдөлмөрчид, МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал, Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн II чуулганыг шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлэх ажилд шинэ их амжилт олж МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхаглаж, анхдугаар үндсэн хууль баталсны 50 жилийн ой зэрэг түүхэн тэмдгэлт үйл явдлыг угтаж 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд улам идэвхтэй оролцон хөдөлмөрийн шинэ шинэ амжилт гаргах зориг эрмэлзэл дүүрэн байна.

ЗОХИОСОН АЖЛЫН ҮР ДҮН


Малын зүй бус хорогдлыг багасгах, төл хүлээж авах бэлтгэл хангах тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол, нөхөр Ю. Цэдэнбалын албан даалгаврыг биелүүлэхэд Баянцагаан сумын «Өрнөх-амьдрал» нэгдлийн зөвлөл бүх ажлаа чиглүүлж уул тогтоол, даалгаврыг сум, бригадын хөдөлмөрчид, суурийн малчдад өргөн таниулж, малчид хөдөлмөрчдөөр нэмэлт үүрэг амлалт авахуулан бригадын өдөрлөгөөр тайлбарлан таниулах ажил зохиов.

Малын зүй бус хорогдлын талаар сүүлийн 3 жилийн судалгаа гаргаж, намын үүрийн бүх гишүү-

дийн хурлаар хэлэлцэж зохих арга хэмжээ авлаа. Мал өвөлжүүлж, хаваржуулах ажил, малын арчилгаа, маллагаа, тэжээллэг, төл бойжуулах ажлын явц зэрэгт сумын малын зүй бус хорогдлын комисс, төл хүлээн авах штабтай хамтарч үзлэг хийж илэрсэн дутагдлыг газар дээр нь засах арга хэмжээ авчээ.

Эдгээр арга хэмжээний дунд том мал, төлийн хорогдол гарч байсан зарим сууриудад хорогдлыг зогсоож, одоо тус сумын хамт олон малын зүй бус хорогдлыг сүүлийн 3 жилийн дунджаас 40-45 хувь багасгах зорилттой ажиллаж байна.

Д. БАНЭРАГЧ



Аймгийн Холбооны газрын олон хотын залгагч Б. Цэрэндолгор холбооны байгууллагад 10 гаруй жил ажиллаж байгаа дадлага туршлагатай холбоочны нэг юм.

Тэрээр 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд тодорхой үүрэг авч ажиллан, энэ оны эхний хагаст жилийн төлөвлөгөөгөө хугацаанаас нь 1 сар 15 хоногийн өмнө үзүүлэлт бүрээр нь 111-131 хувиар биелүүлж мэргэжил нэгт нөхдөө хошуучилж явна.

ЗУРАГ ДЭЭР: Б. Цэрэндолгор ажил дээрээ.

Б. ЦЭРЭНДАШ, Л. ДАМДИНДОРЖ нарын авсан гэрэл зураг

ЗУН ЦАГИЙН ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛ

Зуны улиралд хөдөлмөрчдийн дунд улс төр, соёл хүмүүжлийн ажлыг тусгай хуваарь, төлөвлөгөөтэй зохиодог уламжлалтай болж энэ ажилд нилээд туршлага хуримталаа.

Хөдөлгөөний хөдөлмөрчдийн дунд зохиодог соёл, хүмүүжлийн ажилд сурталчлах бригад, үдэшлэг, уулзалт, тэргүүн туршлагын сургууль, бригадын өдөрлөг, байгууллага сурталчлах өдөрлөг зэрэг хэлбэрийг улам боловсронгуй болгон хэрэглэж байгаагийн дээр зун, намын улиралд соёл хүмүүжлийн ажлыг «Өргөн айлсалтад» төвлөрүүлэн зохиодог туршлага нилээд газар нэвтэрч байна.

Аймгийн Намын хороо, өнгөрсөн зун, намын улиралд отор, өргөн айлсалт, сүү хүлээн авах тасагт зохиох ухуулга, хүмүүжлийн ажлын арга зүйн удирдамж, хуваарийг хол-

богдох сэдэв, ашиглах материалын хамт гаргаж төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй шалган туслах хэсгийг сумдад ажиллуулж лекц яриаг шалган туслах ажилтай хослон зохиосон байна.

Баян-өнжүүл, Баянцогт сумд өргөн айлсалтыг зохион байгуулж, соёл хүмүүжлийн ажлыг явуулах эхлэлтийг хийв.

Гэвч зуны улиралд мал аж ахуйн суурь, үйлдвэр албан газарт явуулах ухуулга хүмүүжлийн ажлыг сулруулах, түүгээр ч барахгүй улс төрийн сонсгол, лекцээ явуулахгүй таслах зэрэг дутагдал зарим сум, байгууллага дээр өнгөрсөн зун үзэгдэж байв.

Малчид ялангуяа оторчлод хүрч ухуулга хийх, захиалсан хэвлэлийг хүргэх, урлаг соёлоор үйлчлэх асуудлыг төдий ланхаардаггүй дутагдал за-

рим сумын нам, олон нийт, ХАА-н байгууллага дээр үзэгдэж байсныг хэрхэвч давтаж болохгүй.

Энэ зуны соёл хүмүүжлийн ажлын агуулга, үр нөлөөг дээшлүүлэх нь намын байгууллагуудын одоогийн нэг чухал зорилт мөн.

Энэ зун явуулах хүмүүжлийн ажилд соёл олон нийтийн байгууллагаас дангаараа болон хамтран гүйцэтгэх үүргийг тодруулан зааж явдал нь шалгаж туслах ажлыг сайжруулж, эцэст нь тодорхой дүгнэх хэрэгтэй байна.

Энэ зуны хүмүүжлийн ажлыг МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтсан социалист уралдааныг өрнүүлж сурталчлах ажилтай нягт холбон зохиох нь чухал.

Энэ нь мал аж ахуйн суурь, үйлдвэрийн цех,

амралт, зуслан, хөдөлмөрчдийн гэр орноор зохиох улс төр, хүмүүжлийн ажлын өнөөгийн үндсэн сэдэв мөн.

Түүхт ой угтсан социалист уралдааны үүргийн биелэлт, 1974 оны үйлдвэрийн ба мал өсгөх төлөвлөгөөг биелүүлэх, малын зүй бусын хорогдлыг багасгах, отор сайн зохион байгуулан малд тархга хүч авахуулах, бүтээгдэхүүний бэлтгэлийн болон хашаа, худал барих, тэжээл бэлтгэх төлөвлөгөөг хангахад чиглүүлэн энэ зуны ухуулга хүмүүжлийн ажлыг аж ахуй, соёлын ээлжит зорилттой нягт холбон сурталчлахад намын байгууллага, ухуулагч, улс төрийн мэдээлэгчид онцгой анхаарвал зохино.

Зуны улиралд хүн ам сүүний тасаг, зуслан амралт, сувилалын газар «Өргөн айлсалтад» олноор төвлөрдөг учраас тэнд зохиох улс төр, хүмүүжлийн ажилд ихээхэн ан-

хаарах хэрэгтэй.

Зуны улиралд явуулах суурийн хүмүүжлийн ажил МАХН-ын Төв Хорооны программаар 6 дугаар сараас эхлэн явагдаж байгаа тул өвөл, хавар зохион байгуулсан дүнг нам, олон нийтийн байгууллагын хурал, бригадын өдөрлөгөөр хэлэлцэн урьдаас сайн бэлтгэж чанартай хийх, сүү хүлээн авах тасаг, мал оторлолтын үеийн «Өргөн айлсалт», «Отрын төвд» төвлөрүүлж хийх, суурийн багш, зөвлөх багшийн хүчиг сайн ашиглах нь одоогийн нэг гол зорилт мөн.

Зуны хүмүүжлийн ажилд удирдах ажилтан, соёл урлагийн ба хөдөлмөрийн сайчуудыг өргөн оролцуулах, алслагдсан суурь, отроор яваа малчдад нүүдлийн кино, номын сан, автоклуб, хүн, мал эмнэлэг, худалдаагаар үйлчлэхэд анхаарах нь чухал байна.

Б. ЦЭРЭНПҮРЭВ

Илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтад оролцогчдоос нийт илгээлтийн эзэд, залуу малчдад хандаж гаргасан УРИАЛГА

МАХН-ын XVI их хурлын түүхт шийдвэрийг хэрэгжүүлж, улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөний дөрөв дэх жилийн зорилтыг хугацааны нь өмнө тоо чанарын дээд үзүүлэлтээр биелүүлж, орон даяар социалист уралдаанд урьд оныхоос илүү амжилт гаргахын төлөө бүтээл хөдөлмөр ид оргилсон үед тус аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалт болоо.

Аймгийн ХЗЭ-ийн хороо, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөл, АДХ-ын залуучуудын байнгын комиссоос хамтран хийлгэсэн энэ чуулга уулзалтад манай аймагт ажиллаж байгаа хөдөлмөрийн баатрууд, гавьяат цолтон, хувьсгалт тэмцлийн зарим ахмад зүтгэлтнүүд оролцож манай оронд хөдөлмөр-нэр төр, алдар гавьяаны хэрэг болсон тухай өөрсдийн ажил амьдралаас жишээ татан ярьж илгээлтийн эзэн бидэнд сургамж зөвлөгөө өгсөн нь энэхүү чуулга уулзалтын ач холбогдлыг улам өндөржүүлж, ахмад үеийнхний хувьсгалт дайчин, хөдөлмөрч уламжлалаас суралцах сайхан боломж олгосныг сэтгэл хангамжтай тэмдэглэж байна.

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН МАЛЧИН ЗАЛУУЧУУД АА!

—МХЗЭ-ийн XVI их хурлаас дэвшүүлсэн «Мал аж ахуй болзлуучуудын гавштай үйлс мөн» гэсэн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд 100 эхээс бойжуулан авах төлийн тоог МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын заалтын хэмжээнээс давуулж, малын зүй бус хорогдлыг гаргахгүйн төлөө хүч хөдөлмөрөө дайчлан ажиллаж, 1974 оны мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд гавштайлан оролцё!

—Баян-өнжүүл сумын «Хайрхан» нэгдлийн хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б.Ажваагийн хотгүй отор хийж, мал сүрэгтээ дээд зэргийн тарга хүч авахуулдаг туршлагаас бүтээлчээр суралцаж «Зузаан тэргэ зудын хуяг» уриан дор отор нүүдлийг сайн зохион байгууля!

—Зоо мал эмнэлгийн анхны мэдэгдэхүүнийг эзэмшиж, малын ашиг шинийг дээд зэргээр ашиглах хөдөлгөөн өрнүүлж, мянгат саальчин болохын төлөө уралдъя!

—Эмнэг сургах секс байгуулж, агт морь, атан тэмээг уналга эдэлгээнд оруулж, сургасан эмнэг малаар жин тээх бүтээлч цувааг зохион байгуулах болон бригад, ердийн хөсгийн хэсэг ажиллуулахад идэвхтэй оролцё!

—Мал сүрэгт арвин их тэжээл бэлтгэх, хашаа барих, худга гаргах зэрэг мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэхэд хошуучлан оролцож, идэвхтэй тусалъя!

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН ТАРИАЛАНЧИД АА!

—Тэргүүний тариаланчдын улсын зөвлөлгөөнөөс дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэн, га тутмаас авах ургацын төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн төлөө хүч чармайлтаа дайчлан ажиллацгаая!

—Хамтран ажиллах, амьдрах, сурахын үлгэр дууриалал үзүүлэн газар ба техникийг үр бүтээлтэй ашиглан, үр тарианы нэгж талбайгаас авах ургацыг тогтвортой нэмэгдүүлэхийн үндэс болсон механикжсан салааны системийг үйлдвэрлэлд нэвтрүүлэ!

—Хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлэхийн тулд үрсэлгийг ваарлан тариалах, услах, бордох, арчлах талаар Батсүмбэрийн САА-н ногоочин, БНМАУ-ын хөдөлмөрийн

баатар Я. Должинжавын туршлагыг бүрэн эзэмшье!

—Техникийн сул зогсолтыг багасгаж, хүчин чадлыг гүйцэд ашиглах замаар машин, тракторын паркын хүчин чадлыг 85 хувиас доошгүй ашиглах, засвар үйлчилгээг сайжруулан сэлбэх материалыг хэмнэх, Өндөрширээт сумын «Хөгжил» нэгдлийн тракторч, илгээлтийн эзэн, улсын аварга хадланч Н. Болдын туршлагыг эзэмших хөдөлгөөнийг өрнүүлэ!

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН АЖИЛЧИД АА!

Ажилчин бүр эзэмшиж байгаа машин, агрегат, механизмын хүч чадлыг бүрэн эзэмшиж ашиглах, ажлын байрны хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, цагийн гарздалыг тууштай багасгах, минут бүрийг үр ашгтай ашиглахын төлөө хүч чармайлтаа дайчлан ажиллацгаая!

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДУНД СУРГУУЛЬ ТӨГСГӨХ ОХИД, ХӨВГҮҮД ЭЭ!

—Бидний нэгэн адил дунд сургуулиа төгсгөөд МАХН-ын уриа, МХЗЭ-ийн илгээлтээр ХАА-н үйлдвэрлэл дээр гарч, хөдөлмөрөөрөө алдар нэрээ дуурсган ажиллахыг уриалъя!

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН НИЙТ ЗАЛУУЧУУД АА!

—Ажлын салбар бүрт анхан шатны бүртгэл тооцоог бүрэн нэвтрүүлэх ажлыг өөрсдийн биеэр үлгэрлэн ажилла!

—Төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхийн тулд угтвар төлөвлөгөөг зохион уралдах, эдийн зас-

гийн тооцоот үүргийг боловсруулан авч хэрэгжүүлэх, уралдааны гэрээтэй ажиллах, залуучуудын гавштайч бригад байгуулах зэргээр — социалист уралдааны дэвшилт хэлбэрийг дэмжин дэлгэрүүлэ!

—Ахмад тэргүүний хүмүүс, хөдөлмөрийн баатруудын арга туршлагаас шамдан суралцаж, тэдний хөдөлмөрч уламжлалыг эзэмшье!

—Ажиллахын зэрэгцээгээр оройн ба эгнээгээр сурч, срөнхий боловсролоо ахиулах, мэргэжлийн зэргээ дээшлүүлэх, хос мэргэжил эзэмших хөдөлгөөн өрнүүлэ!

—Ахуйд соёл нэвтрүүлэх талаар нийт хөдөлмөрдөд үлгэр дууриал үзүүлэхийн зэрэгцээ хөдөөгийн хөдөлмөрчдийн боловсролыг дээшлүүлэхэд тодорхой тусалцаа үзүүлэ!

—1973 оны бүх ард түмний социалист уралдааны тэргүүний сайчуудын чуулга уулзалтанд оролцогчдын уриалгыг хэрэгжүүлж таван жилийн төлөвлөгөөг дөрвөн жилд биелүүлэх, зургаан өдрийн ажлыг таван өдөрт хийх хөдөлгөөнд гавштайчлан оролцё!

Аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтанд оролцогчид бидний энэхүү уриалгыг дэмжин, өөрсдийн ажилд хэрэгжүүлэн 1974 оны аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг хугацаанаас нь өмнө давуулан биелүүлэх тэмцэлд социалист уралдааны явцыг улам эрчимжүүлж, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг хөдөлмөрийн шинэ шинэ амжилтаар угтахыг нийт илгээлтийн эзэн, залуу малчдад хандан уриалж байна.

Аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтад оролцогчид
Зуунмод 1974—5—30



Батсүмбэрийн САА-н 1 дүгээр бригадын саальчин илгээлтийн эзэн С. Эрдэнэ-цэцэг 1973 онд 102 мянган литр сүү саахаас 102,7 мянган литр сүү сааж, төл бойжуулах болон бусад үйлдвэрлэлийн даалгаврыг 100 хувь биелүүлсэн амжилтаа энэ онд улам бататгах зорилттой ажиллаж байна.



Өндөрширээт сумын «Хөгжил» нэгдлийн тракторч, илгээлтийн эзэн Н. Болд хадлан хадах төлөвлөгөөг 1971 онд 180 хувиар биелүүлж сумын аварга хадланч, 1972 онд 208 хувиар биелүүлж аймгийн аварга хадланч, 1973 онд 215 хувиар биелүүлж БНМАУ-ын аварга хадланч «цолоор» тус тус шагнагджээ.



ЗУРАГ ДЭЭР: (Зүүн гараас) Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн «Тэргүүний малчин залуу» алтан медальт мянгат саальчин, илгээлтийн эзэн Г. Мямгарсүрэн, Мөнгөнморьт сумын «Улаанбаатар» нэгдлийн саальчин, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Ичинхорлоогоос зөвлөгөө авч байгаа нь.

Д. БАДАРЧ-ийн авсан гэрэл зураг

ОТРЫН ОЛЗ

Нарстай, Халзан, Илланганы энгэрээр хонин сүрэг тэлхэн бэлчиж хонин хариулан яваа хоньчин эзэн нь морно унахаасаа хөтлөн явах нь олонтой нэгэн хоньчныг нутаг усныхан нь андахгүй.

Энэ хонь хариуцаж яваа хүн чинь Гүрдагва л байна.

Хониныхоо ая тавыг алдуулахгүй гэж л ингэж явдаг хүн дээ.

Аль л бэлчээрийн соргог сайхныг даган нүүж явах юм. Эдний мал тарган байх нь ч аргагүй гэлцэнэ.

Гүрдагвын хариуцан энэ жил улсын бэлтгэлд ний-

лүүлсэн 868 эр шүдлэн хонь нэг бүр нь 45 кг, ямаа нь 34 кг жин татсан байна.

Энэ нь нэгдлийн үйлдвэрлэлийн даалгавраас эр шүдлэн хонь 139, ямаа 4-ийг хэмнэжээ.

Үйлдвэрлэлийн даалгавраар 11 кг ноолуур тушаахаас 14 кг-ыг тушааж ноолуурынхаа 98 хувийг 1 дүгээр зэрэгт тушаажээ.

Энэ бүхнээ «Миний отроос олсон олз» гэж Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн Нарстай бригадын хоньчин Гүрдагва гуай ярьж байна.

Д. ОТГОН



Лун сумын «Энх-туул» нэгдлийн адуучин, илгээлтийн эзэн Б. Балжинням 200 гаруй адуу хариуцан маллаж 1973 онд 24 гүүнээс 24 унага бойжуулж 55 өмнөг сургасны дээр энэ жилийн хөөвөр, хялгасны төлөвлөгөөг 100 хувь биелүүлжээ.



Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

ӨМЧ ХАМГААЛАЛТАД ҮЗЛЭГ ХИЙВ

Саяхан ХБУ газрын системийн анги трестүүдийн тайлан тооцооны ажил, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, өр авлага хэрхэн барагдуулж байгаад аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас үзлэг хийв.

Үзлэгийн дүнгээс үзэхэд ХБУ газар нь 1973 оны эцэст 828,1 мянган төгрөгний дутагдал шамшигдалтай байсан бол 1974 оны I улирлын байдлаар 124,7 мянган төгрөг хөрөнгө, 55,8 мянган төгрөгний дутагдал нэмэгдэж, одоогийн байдлаар 759,2 мянган төгрөгний дутагдал шамшигдалтай байна.

Нийт дутагдал шамшигдал 20,2—8,9 хувийг

Эрдэнэ, Лүн, Баян-өнжүүл сумын ХБ анги, Зуунмод хотын ХБ-ийн трест эзлэж байна.

Эдгээр дутагдал шамшигдалын гол нь эд хариуцагчдыг анх ажилд авахдаа хамт олноор хэлэлцүүлж, эрх үүргийг нь судлуулж авдаггүй, хийсэн ажлын тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлдэггүй, тэднийг олон дахин халж солих явдлаас шалтгаалж байна.

Түүнчлэн социалист өмч хөрөнгийн хадгалалтанд тавих дотоодын хяналт шалгалтыг сайжруулж жил, улирлын тооллого тооцоог зохих тогтоол зааврын дагуу чанартай хийдэггүй байна. Ийм учраас нийг-

мий өмчийг нүдний цэцгий мэт хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглан зарцуулах, аж ахуйч ажиллагааг үйлчилгээний цэг болгонд тууштай нэвтрүүлж, өр авлагыг хураан барагдуулах, гүйлгээ хөрөнгийн эргэлтийг сайжруулах боломжийг хангах явдал дээрх ХБ анги, трестүүдийн чухал зорилт болж байна.

Тооллого тооцоог чанартай явуулж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж өр төлбөр үүсч бий болох, өмч хөрөнгийг идэвх ашиглах, үрэгдүүлэх явдлыг таслан зогсоох талаар хот, хөдөөгийн нийт анги, трестүүдийн удирдах ажилтан, эд хариуцагчид анхаарах нь чухал.

Санхүүгийн хэлтсийн ажилтан Д.СҮГАРСҮРЭН

Цөөн мөрөөр

БНМАУ-ын шатрын спортын мастер, мал эмнэлгийн ухааны дэд эрдэмтэн Даваатай Зуунмод хотын шатар, сонирхогчид уулзалт хийлээ. Мастер Даваа, орчин үеийн шатрын спортын хөгжилт, дэлхийн шатрын аваргын тэмцээний талаар сонирхолтой яриа хийж шатарчдад үнэтэй зөвлөлтөө өгөв.

МОНХДОРЖ

Угтаалын САА-н хүүхдийн цэцэрлэгийн хамт олон, эцэг эхчүүд өндөр бүтээлийн нэг өдрийн ажил зохиож хүүхдийн тоглоомын талбайд арваад нэр төрлийн тоглоомыг хаягдал мод, төмөр материаллаар хийж хүүхдийн баяраар ашиглалтанд орууллаа.

ДАВААХҮҮ

ТАНЫ СОНИРХОЛД

Дэлхийн бүх хүний 34 хот дэлхийн 133, бумаас хувь хотод сууна. дээш хүнтэй хот 1784 Нэг саяас дээш хүнтэй байдаг байна.

★ 1974 оны зун цагт явагдах хүүмүүжлийн ажлын цагийн хуваарь

ЛХАГВА ГАРИГ	
Төвлөрсөн газруудад явагдах хууль эрхийн хичээл	19—21 цаг
ПҮРЭВ ГАРИГ	
Нам, олон нийтийн байгууллагын хурал	19—21 цаг
БААСАН ГАРИГ	
Улс төрийн сонсгол	7 ³⁰ —8 цаг
Нийтийн лекц	19—21 цаг
БЯМБА ГАРИГ	
Соёл, олон нийтийн ажлууд	17 цагаас
НЯМ ГАРИГ	
Үзвэрүүд	
Тайлбар: Энэхүү хуваарийг 6 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1 хүртэл аймгийн хэмжээгээр мөрдөнө.	
Аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтэс	

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭРЭНДАШ

ЗАРЛАЛ

Жаргалант сумын харьяат Лувсан овогтой Цэнд-банзрагч, Өндөрширээт сумын харьяат Намжил овогтой Болд нар иргэний 335464, 328645 тоот үнэмлэхээ тус тус гээгдүүлсэн тул хүчингүйд тооцон.



Төвийн нутгаар сарын дундаж агаарын температур 13—15 градус дулаан, хэвийн хэмжээнд шөнөдөө сар шинийн эхээр 7—8,22—23-ны үеэр 0—5 градус дулаан, но-

Дэлгэрхаан сумын «Залуучуудын хөгжил» нэгдлийн Давст бригадын Б.Чулуулмаг, Б.Доржнамдаг, Б.Хойлог нарын олон мал-

ТОВЧХОН

чид бэлтгэлд тушаасан үхэр бүрээ 400—620 кг жинд хүргэн тушааж цөөн тооны чанар сайтай малаар улсын төлөвлөгөөг биелүүлээ.

Ш.ЧҮЛТЭМДАРЖАА

Зургадугаар сард

чир хүйтрэлттэй, бусад хугацаанд 6—11 градус дулаан. Өдөртөө 5—10, 17—21, сар хуучийн эцсээр 23—28 градус, бусад хугацаанд 18—23 градус дулаан, 40—60 мм буюу хэвийн хэмжээнд зарим газраар хэвийн хэмжээнээс бага,

25—30 мм бороо орно. Сар шинэ ба 2 дугаар 10 хоногийн эхээр 20—25-нд солигдмол үүлтэй. Зарим газраар дуу цахилгаантай түр зуурын бороо орно. Бусад хугацаанд бага зэрэг үүлтэй, бороо орохгүй. Салхи баруунаас секундэд 3—7 метр байна. Сар шинийн

эхэн ба эцэс, сар хуучийн эхээр салхи баруун хойноосоо секундэд 10—14 метр хүртэл ширүүснэ.

Төв ба зүүн зүгийн нутаг, баруун зүгийн нутгийн хойт хэсгээр ахуйн хэмжээний бороо 6 дугаар сарын 9—12, 15—17, 21—25-ны үеэр орох бөгөөд сарын эхээр төвийн нутгийн уулархаг хэсгээр нойтон цас орж болзошгүй байна. Энэ

сард бүх нутгаар хэвийн хэмжээний орчим дулаан байх боловч агаарын температур 5—8 градус хүртэл буурч, сарын эхээр өмнө зүгийнхээс бусад бүх нутагт хөрсний гадарга 1—5 градус хүчтэй ноцир хүйтэрч сар хуучийн эцсээр салхины хүч 14 метр секунд хүртэл ширүүсэх төлөвтэй байна.

Ус. цаг уурын товчоо